



Journal of Security and Defense Studies

Journal homepage:
https://mids.gov.mn/category/ayulgui_baidal-2/

ISSN: 2220-9115, E-ISSN: 2708-1230



Research Article

DOI: <https://doi.org/10.65816/jsds.2026.02.012>

The tactical-psychological environment of future warfare and new challenges for military psychology

Tsetsenkhuu Ganbat

Major, Senior Research Fellow, Center for Military Psychology, Defense Research Institute of Mongolia

E-mail address: Gama99889988@gmail.com, ORCID:0009-0001-6347-855X

Received: 16 June 2026

Revised: 23 June 2026

Accepted: 28 June 2026

Published online: 28 July 2026



ABSTRACT

Special military operations (SMO) have fundamentally changed the means, tactics, and psychology of combat. The absolute transparency and total lethality of modern combat environments require the search for completely new tactical, technical, and psychological forms of combat confrontation. Experience from past wars and recent military events demonstrates that, given the creation of totally lethal zones on the battlefield, combat activity must be transferred to safer environments. This article substantiates the inevitability of partially transferring combat confrontation to underground and outer space. Combat operations in these environments will require soldiers to operate in the absence of external reference points, isolated from the main forces, to solve combat missions alone, without the ability to maintain contact with fellow soldiers, to utilize skills for surviving in isolation, to combat combat robots and robotic systems, and to utilize artificial intelligence as a resource. Military psychology is designed to help combatants master the necessary psychological resources for effective combat in future wars.

Keywords: Future warfare, battlefield transparency, underground warfare, psychological effects of isolation, artificial intelligence.

Ирээдүйн дайны тактик-сэтгэл зүйн орчин ба цэргийн сэтгэл судлалын шинэ сорилт

Цэцэнхүү Ганбат

БХЭШХ-ийн Цэргийн сэтгэл судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, хошууч,
Gama99889988@gmail.com, ORCID:0009-0001-6347-855X

ХУРААНГУЙ

Цэргийн тусгай ажиллагаа нь цэрэг дайчдын сэтгэл зүйд гүн гүнзгий хар ул мөр үлдээдэг байна. Аюул заналхийлэл, найз нөхдийн амь үрэгдэх болон шархдах тохиолдол, дайсныг устгах ажиллагаанд биечлэн оролцох, байлдааны ажлын үр дүнгийн хариуцлага хүлээх, байлдааны бүсэд хэт удаан хугацаагаар байх, гэр бүл болон ойр дотнын хүмүүсээсээ холдох, өдөр тутмын амьдралын нөхцөл огцом доройтох зэрэг хүчин зүйлс нь цэргийн алба хаагчдад байлдааны стресс (combat distress), байлдааны сэтгэцийн гэмтэл үүсгэх бөгөөд улмаар клиникийн

түвшиний сөрөг сэтгэл зүйн үр дагаврууд илрэх нөхцөлийг бүрдүүлдэг.

Өмнөх үеийн дайн болон сүүлийн үеийн цэргийн мөргөлдөөний туршилагаас үзэхэд, байлдааны талбарт бүхэлдээ өндөр эрсдэлтэй бүсүүд бий болж байгаа нөхцөлд байлдааны үйл ажиллагааг харьцангуй аюул багатай орон зай, орчин руу шилжүүлэх шаардлага улам бүр нэмэгдэж байна.

Энэхүү өгүүлэлд байлдааны ажиллагааг хэсэгчлэн газар доорх болон сансрын орон зайд шилжүүлэх нь зайлиггүй болохыг үндэслэн авч үзсэн болно. Ийм орон зайд явагдах байлдааны ажиллагаа нь цэргийн алба хаагчдаас газар зүйн баримжаа (ориентир) байхгүй нөхцөлд ажиллах, үндсэн бүрэлдэхүүнээсээ тусгаарлагдсан үед бие даан шийдвэр гаргаж, үүрэг гүйцэтгэх, харилцаа холбоо тасарсан нөхцөлд байлдааны даалгаврыг гүйцэтгэх, тусгаарлалт ба ганцаардлын орчинд амьд үлдэх үр чадвар, мөн байлдааны робот болон роботжуулсан системтэй сөргөлдөх чадамжийг шаардана. Түүнчлэн хиймэл оюуныг байлдааны ажиллагааны нэмэлт нөөц, шийдвэр гаргалтын туслах хэрэгсэл болгон ашиглах шаардлага өсөн нэмэгдэнэ.

Цэргийн сэтгэл судлал нь ирээдүйн дайны нөхцөлд үр нөлөөтэй сэтгэл зүйн ажиллагааг хангах зорилгоор шаардлагатай сэтгэл зүйн нөөц, дасан зохицох чадвар, сэтгэлгээний тогтвортой байдлыг бүрдүүлэхэд чиглэсэн онол-практикийн үүрэгтэй юм.

Түлхүүр үгс: Ирээдүйн дайнууд, байлдааны талбарын ил тод байдал, газар доорх байлдааны ажиллагаа, тусгаарлалтаас үүдэх сэтгэл зүйн нөлөөлөл, хиймэл оюун.

ОРШИЛ

ОХУ-ын Зэвсэгт хүчний Украинд явуулж буй цэргийн тусгай ажиллагаа (ЦТА) нь сүүлийн 25 жилийн турш ирээдүйн дайны шинж чанарыг урьдчилан таамаглах, мөн цэргийн сэтгэл судлалын агуулга ба зохион байгуулалтад гарах өөрчлөлтийг тодорхойлохыг зорьж ирсэн шинжээчдийн дүгнэлтийн үр дүнг тусган харуулсан нэгэн төрлийн туршилтын “толь” болон хувирсан байна.

Ийм төрлийн үнэлгээ, урьдчилан таамагласан дүн шинжилгээ нь өмнө нь хийгдсэн зарим таамаглал бодит байдалтай маш хол зөрсөн бол, нөгөө хэсэг нь өнөөгийн цэргийн сэтгэл судлалд бодит байдлыг нэлээд нарийн таамагласан боловч практикт цэргийн болон сэтгэл зүйн үйл ажиллагааг удирдан чиглүүлэгч талуудад хангалттай анхаарагдаагүй байсныг харуулж байна.

Мэдээж ирээдүйг урьдчилан таамаглах нь асар их урьдчилсан судалгаа, өнгөрсөн ба өнөөгөөс ирээдүй үйл явцад нөлөөлөх хамгийн чухал хүчин зүйл, механизмын илрүүлэлтийг шаарддаг нарийн төвөгтэй ажил юм. Үүний зэрэгцээ энэ нь тодорхой хэмжээний шинжлэх ухааны зориг, эрсдэлтэй шууд холбоотой. Учир нь эрт орой хэзээ нэгэн цагт ирээдүй бодит үр дүнгээрээ илэрч, хүн бүр түүнийг хийсэн таамаглалтай харьцуулах боломжтой болдог.

Иймээс XXI зууны эхний дөрөвний нэгт, цэргийн сэтгэл судлалын шинжлэх ухаан ба практик тал руугаа харьцангуй эрчимтэй хөгжиж байсан ч ирээдүйн дайны шинж чанарыг урьдчилан тодорхойлох, түүн дээр үндэслэн цэргийн сэтгэл судлалын ирээдүйн дүр төрхийг тодорхойлох оролдлого харьцангуй цөөн байсан гэж үзэж болно.

Энэхүү өгүүллийн зорилго нь цэргийн тусгай ажиллагааны улмаас гарсан хувьсал өөрчлөлтүүдийг харгалзан, ирээдүйн зэвсэгт тэмцлийн шинж чанарыг тодорхойлох хүчин зүйлсийг тогтоох явдал юм. Мөн энэ салбар дахь байлдааны болон сэтгэл зүйн гол чиг хандлагыг шинжлэх ухааны “ойрын харах хүрээ” болон “алсын харах хүрээ”-нд урьдчилан таамаглаж, шинэ төрлийн байлдааны ажиллагааны туршлагад шаардлагатай цэргийн сэтгэл судлалын ерөнхий дүр төрхийг тоймлон гаргахыг зорилоо.

Судалгааны явц

Цэргийн сэтгэл судлалын хөгжил нь дайн, байлдааны хувьсан өөрчлөгдөж буй шинж чанартай салшгүй холбоотой. Дайн, байлдаан нь цэргийн сэтгэл судлал болон цэргийн шинжлэх ухааны бусад салбарын хөгжлийн хэрэгцээ, судалгааны чиглэлийг тодорхойлох гол хүчин зүйлс болдог. Үүний зэрэгцээ тэдгээрийн шинж чанар нь цэргийн алба хаагчдын ёс суртахуун-сэтгэл зүйн болон байлдааны бэлтгэлд тавигдах шаардлагыг төлөвшүүлж, байлдааны нөхцөл дэх хувь хүн, хамт олны зан үйл, нийгэм-сэтгэл зүйн үйл явц, мөн байлдааны ажиллагааны дараах сэтгэл зүйн хариу урвал, үр дагаврын онцлогт шууд нөлөөлдөг.

Ирээдүйн дайныг урьдчилан таамаглах, цэргийн сэтгэл судлал цаашид хэрхэн хөгжихийг судалсан шинжлэх ухааны хандлагаас авч үзэхэд, тэдгээрийн гол үндэс нь цэргийг бүх талаас хөгжүүлэхэд нөлөөлдөг хүчин зүйлсийг зөв тодорхойлох явдал байдаг.

Тухайлбал, Cronin цэргийн сэтгэл судлалын ирээдүйн хөгжлийг тодорхойлох дөрвөн үндсэн хүчин зүйлийг онцолсон. Үүнд:

1. Технологийн дэвшил;
2. Төсвийн өөрчлөлт;
3. Улс төрийн өөрчлөлт;
4. Хүн ам зүйн өөрчлөлт.

Зохиогчийн үзэж байгаагаар эдгээр хүчин зүйлсэд тухайн улсын цэргийн аюул занал, ирээдүйн дайны талаарх ойлголт тусгагдсан байдаг. Гэвч бодит амьдрал эдгээр хүчин зүйлсийн заримынх нь хязгаарлагдмал шинжийг олон удаа харуулсан байдаг.

Жишээлбэл, ЗХУ Дэлхийн II дайны үеэр цэргийн сэтгэл судлал хөгжихөд улс төрийн хувьд таагүй нөхцөл (цэргийн сэтгэл судлалыг бараг хориглосон байдал), санхүүжилтийн маш бага түвшин, мөн хүн ам зүйн огцом өөрчлөлт (олон сая насанд хүрсэн хүн амын алдагдал, зарим үндэстний нүүлгэн шилжүүлэлт гэх мэт) зэрэг нөхцөл давамгайлж байсан ч тухайн үеийн Зөвлөлтийн цэргийн сэтгэл судлал нь нисгэгч, тагнуулч, агаарын явган цэрэг, тэнгисийн цэрэг, холбоочин, байр зүйн зургийн болон дүн шинжилгээний баг, удирдлагын ур чадварыг дээшлүүлэхтэй холбоотой олон шинэлэг онол-практикийн шийдлүүдийг төрдөө санал болгож чадсан юм.

Лоуренс ба Мэттьюс нар ирээдүйн цэргийн сэтгэл судлалын чиг хандлагын гол хувьсагч хүчин зүйлсийг хурдацтай хөгжиж буй шинэ технологи болон байлдааны үр дүнд шийдвэрлэх нөлөө үзүүлдэг шинжлэх ухаан гэж үздэг. Эдгээр байр суурьтай санал нийлэхгүй байх боломжгүй юм. Үнэхээр хүн төрөлхтний түүхийн туршид цэргийн технологи нь дайны шинж чанарыг өөрчилж ирсэн бөгөөд эдгээр өөрчлөлтүүд нь цэргийн сэтгэл судлалд бодит байдалд тусгалаа олж, сэтгэлгээ сайтай удирдлага, эрдэмтэд, төрийн алба хаагчид болон сэтгэл судлаачдын өмнө шинэ асуултуудыг байнга тавьсаар ирсэн (Matthews 2020).

А.Г. Караяни олон төрлийн хандлагуудыг нэгтгэн дүгнэхдээ ирээдүйн дайны онцлогийг тодорхойлох ОХУ-ын батлан хамгаалах номлолын заалтуудын ач холбогдлыг онцолжээ. Түүнчлэн орчин үеийн байлдааны туршлагаас гарч буй шинэ чиг хандлагууд, цэрэг болон иргэний салбарын хамгийн хурдтай хөгжиж

буй технологиуд, мөн батлан хамгаалах ба аюулгүй байдалд ач холбогдолтой байж болох шинжлэх ухааны салбаруудын динамик хөгжлийг чухалчилж үзжээ (Караяни 2026).

Дэлхийн тэргүүлэх цэргийн гүрнүүдийн ирээдүйн дайны талаарх батлан хамгаалах үзэл баримтлал

ОХУ-ын цэргийн номлол (2014 онд боловсруулсан) нь Зэвсэгт хүчний бэлтгэгдэх ёстой ирээдүйн дайны шинж чанарыг тодорхойлохдоо дараах үндсэн онцлогуудыг тэмдэглэсэн байдаг (*Внешняя политика/Основополагающие документы 2014*). Ирээдүйн цэргийн ажиллагаа нь цэргийн хүчийг цогц байдлаар ашиглахын зэрэгцээ улс төр, эдийн засаг, мэдээлэл болон бусад цэргийн бус шинжтэй арга хэмжээг өргөн хүрээнд хэрэглэх замаар явагдана гэж үзсэн. Эдгээр арга хэмжээг олон нийт доторх эсэргүүцэн тэмцэх чадавх болон тусгай ажиллагааны хүчнийг өргөн ашиглан хэрэгжүүлнэ. Мөн ирээдүйн дайнд дараах чиг хандлага давамгайлна гэж тодорхойлсон. Үүнд: өндөр нарийвчлалтай зэвсэг, гипер дууны зэвсэг, радио электрон тэмцлийн хэрэгсэл, цөмийн зэвсэгтэй дүйцэхүйц үр нөлөө бүхий шинэ физикийн зарчимд суурилсан зэвсэг, мэдээлэл-удирдлагын систем, түүнчлэн нисгэгчгүй нисэх хэрэгсэл, автономт далайн төхөөрөмжүүд, роботжуулсан зэвсэг, цэргийн техник зэргийг масс хэлбэрээр ашиглах явдал багтана. Ирээдүйн байлдааны ажиллагаа нь дайсны нутаг дэвсгэрийн бүх гүнд зэрэг нөлөөлөх байдлаар, мэдээлэл даяаршлын орон зай, агаар-сансрын орон зай, хуурай газар болон далайн орон зайд нэгэн зэрэг явагдах онцлогтой байна. Мөн байлдааны ажиллагааны явцад объектуудыг сонгомол байдлаар өндөр нарийвчлалтай устгах, цэрэг хүчний маневр болон галын удирдлагын хурд огцом нэмэгдэх, мөн янз бүрийн хөдөлгөөнт бүлэглэлүүдийг өргөн ашиглах зэрэг шинжүүд давамгайлна гэж тодорхойлсон байна.

Эдгээр урьдчилсан (прогностик) заалтууд, 12 жилийн өмнө томъёологдсон боловч өнөөдөр ялангуяа ойрын ирээдүйн таамаглалын хүрээнд өндөр таамаглах чадвартай байсныг тодорхой харуулж байна. Эдгээр нь шинэ төрлийн цэргийн мөргөлдөөнүүдэд (цэргийн тусгай ажиллагаа болон АНУ ба Израилын Ираны эсрэг явуулж буй дайн гэх мэт) бүрэн хэмжээнд илэрч буй бөгөөд бидний үнэлгээгээр эдгээр таамаглалын хүчин чадал ойрын ирээдүйн дараагийн үе шатанд ч хадгалагдах төлөвтэй байна.

АНУ-ын ирээдүйн дайны талаарх үзэл баримтлал, цэргийн бодлогын чиг хандлага хамгийн тод туссан жишээний нэг нь RAND¹ корпорацийн (англи. Research and Development – Судалгаа ба хөгжүүлэлт) ирээдүйн аюулгүй байдлын орчин, дайн, цэргийн технологийн хөгжлийг урьдчилан таамагласан судалгаанууд юм. Тус байгууллага нь АНУ, Европ, Ойрх Дорнод болон Азийн орнуудын төрийн байгууллагуудад стратегийн судалгаа, шинжилгээний үйлчилгээ үзүүлдэг. RAND-ийн сүүлийн үеийн бүтээлүүдэд ирээдүйн зэвсэгт мөргөлдөөнийг дараах шинж чанартайгаар тодорхойлсон байна (Kulyk and Maidannyk 2026):

- Дайн нь мэдээллийг зориудаар гуйвуулах, төөрөгдүүлэх (информационная

¹ Тайлбар: RAND корпораци нь АНУ-д төвтэй, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах болон төрийн бодлогын асуудлаар судалгаа хийдэг дэлхийн нэр хүндтэй ашгийн бус стратегийн судалгааны байгууллага юм.

мистификация²) ажиллагаагаар дамжуулан эмх замбараагүй байдлыг тасралтгүй бий болгож, удирдах шинжтэй урт хугацааны мөргөлдөөн бөгөөд түүний гол зорилго нь зөвхөн ялалт байгуулах бус, харин өөрийн оршин тогтнох, амьд үлдэх чадварыг хадгална;

- Дайны амжилтыг дайснаа ялах бус, харин мэдээллийн орчин (сошиал медиа)-д өөрийгөө болон өөрийн байр суурийг дэлхийн олон нийт, тэр дундаа дайсанд итгүүлж хүлээн зөвшөөрүүлэх чадвараар хэмжинэ;
- Нисгэгчгүй системүүдийн үүрэг тасралтгүй нэмэгдэх ба хиймэл оюунтай нэгдсэн тохиолдолд энэ нөлөө эрс өснө;
- Агаарын цэрэг, дронууд болон сансрын системүүдийн чадавхыг нэгтгэн уялдуулах;
- Далайн дронуудын ажиллагааны хүрээ тэлж, тэдгээрийг дайсны усан онгоцыг устгах, алсын зайд цохилт өгөх, дэд бүтцийг сүйтгэх, мөн далайн мина цэвэрлэх зорилгоор ашиглах.

АНУ-ын нэр хүндтэй Бизнес эрхлэгчдийн нэг болох Илон Маск (Tesla, SpaceX-ийн үүсгэн байгуулагч) “сөнөөгч онгоцны эрин дууссан, одоо дроны эрин” гэж онцолсон байдаг. Мөн Стивен Хокинг, Илон Маск болон бусад судлаачид автономт зэвсгийн талаар нээлттэй захидалд дурдсанаар, ийм төрлийн зэвсэг нь хүний оролцоогүйгээр байгаа сонгон довтлох чадвартай бөгөөд тодорхой шалгуураар хүнийг илрүүлж устгах чадвартай роботжсон системүүд (жишээ нь, зэвсэглэсэн автономт платформууд) аль хэдийн бий болсон бөгөөд ирээдүйд ийм шинж чанартай пуужингийн системүүд ч хөгжих магадлалтай гэж үзжээ ([Радио РБК 2021](#)).

Дунд хугацааны таамаглалын хүрээнд Илон Маск ойрын 10 жилийн дотор 1 сая робот такси болон 1 сая хүн дүрст робот (Optimus)-ыг үйлдвэрлэлд нэвтрүүлнэ гэж тооцоолж байна. Эдгээр шийдлүүд нь хоёрдмол зориулалттай байх нь ойлгомжтой бөгөөд робот такси болон хүн дүрст роботууд нь ирээдүйн дайны нөхцөлд чухал нөөц, потенциал хүчин болж ашиглагдах боломжтой юм.

Зарим эрдэмтдийн бүтээлүүдэд тусгагдсан таамаглал

Энэтхэгийн цэргийн сэтгэл судлаачид Н.Махешвари, В.Кумар нар ойрын болон алс ирээдүйн дайны шинж төрхийг тодорхойлохдоо сүлжээ төвт дайн (network-centric warfare), мэдээллийн дайн, платформгүй дайн, кибер дайн, цөмийн-биологийн-химийн дайн, өндөр технологид суурилсан радио электрон тэмцэл зэрэг хэлбэрүүд давамгайлна гэж үзжээ. Тэдний үзэж байгаагаар ирээдүйн зэвсэгт мөргөлдөөнүүдэд цахилгаан соронзон импульсийн (ЦСИ/ЕМР) зэвсэг, үй олноор хөнөөх зэвсэг (YOH3), кинетик зэвсэг, лазерын зэвсэг, хамгаалалтын автоматжуулсан системүүд, энергийн туяан зэвсэг, дууны зэвсэг, цөмийн, биологийн болон химийн зэвсэг, робот-цэргүүд, хиймэл оюунд суурилсан киборг цэрэг, дэвшилтэт ажиглалт тандалтын системүүд болон үл илрэх (stealth) технологид суурилсан зэвсгүүд өргөн хэрэглэгдэх төлөвтэй байна ([Караяни 2026](#)).

Энэхүү таамаглал нь ирээдүйн дайн улам бүр технологижиж, автоматжиж,

² "Информацийн мистификаци" (орос: информационная мистификация) гэдэг нь мэдээллийг зориудаар гуйвуулах, хуурамч дүр зураг бий болгох, төөрөгдүүлэх зорилгоор бодит бус мэдээлэл түгээх үйл ажиллагааг хэлдэг.

хиймэл оюун, робот техник, мэдээлэл-харилцааны дэвшилтэт системүүдэд тулгуурлахын зэрэгцээ хүний сэтгэл зүй, мэдээллийн орчин, кибер орон зайг байлдааны үндсэн талбар болгон хувиргах хандлагатай байгааг харуулж байна.

Гэсэн хэдий ч С.Жохар, У.Кумар нарын үзэж байгаагаар ирээдүйн байлдааны талбарт тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх хамгийн хувьсгалт арга нь сэтгэл зүйн дайн байх болно. Тэд сэтгэл зүйн дайныг технологийн дэвшилтэт хэрэгслүүдийг ашиглан дайсны оюун санаа, танин мэдэхүйн үйл ажиллагаанд нэвтрэн орох, өөрөөр хэлбэл “Танин мэдэхүйн халдлага” (cognitive hacking) хийх үйл явц гэж тодорхойлжээ. Энэхүү аргаар дайсны мэдээлэл боловсруулах чадварыг саатуулах, шийдвэр гаргалтыг доголдуулах, мэдээллийн төөрөгдөл үүсгэх, удирдлага зохион байгуулалтыг алдагдуулах замаар байлдааны ажиллагааг амжилтгүй болгох боломжтой гэж үзсэн байна. Эдгээр эрдэмтдийн үзэж байгаагаар тархины үйл ажиллагаанд суурилсан шууд мэдээлэл солилцох технологи, мета танин мэдэхүйн³ (metacognitive) хэрэгслүүд, шийдвэр гаргалтыг дэмжих эсвэл удирдах системүүд зэрэг дэвшилтэт технологиуд ашиглагдаж болзошгүй. Мөн дайсны тархинд нэвтрэн нөлөөлөх чадвартай нано бөөмсийг ашиглан тэмцэх хүсэл зоригийг сулруулах, алсын зайн мэдрэлийн хяналтын технологиор ухамсар, сэтгэцийн үйл ажиллагаанд нөлөөлөх зэрэг боломжуудыг дэвшүүлжээ (Караяни 2026).

Өмнөд Африкийн цэргийн сэтгэл судлаач Р.С.Бестерийн үзэж байгаагаар ойрын ирээдүйн дайнуудад хиймэл оюун, их өгөгдөл (big data) зэрэг шинэ технологиуд нь цэргийн ажиллагааны хөгжлийг тодорхойлох гол хөдөлгөгч хүчин зүйлсийн нэг болно (Bester, Petrus Cornelius 2020). Тэрээр цэргийн хүчнүүд танин мэдэхүйн (cognitive), хуурай газар, агаар, сансар, тэнгис, гипер орон зай⁴, цахилгаан соронзон спектр⁵ болон мэдээллийн орчинд ижил түвшний өрсөлдөгчтэй тэмцэлдэхэд бэлэн байх шаардлагатай гэж үзжээ. Мөн ирээдүйн байлдаанд робот, киборг зэрэг хүн-машины хосолмол системүүдтэй шууд тулгарах нөхцөл үүснэ гэж таамагласан байна.

Р.С.Бестер⁶ цааш нь ирээдүйн дайн маш өндөр хурдтай, өдөр шөнөгүй, тасралтгүй явагдах бөгөөд байлдааны ажиллагааны гол үүргийг роботууд гүйцэтгэх болно гэж тэмдэглэсэн байна. Гэсэн хэдий ч хүн ба машины интеграц улам бүр

³ Тайлбар: Мета танин мэдэхүй (metacognitive) нь хувь хүний өөрийн танин мэдэх үйл явцыг ухамсарлан ойлгох, хянах, үнэлэх болон зохицуулахтай холбоотой сэтгэл зүйн дээд түвшний чадвар юм. Энэ нь хүний өөрийн сэтгэх үйл ажиллагаа, мэдлэг эзэмшилт, асуудал шийдвэрлэх явцыг ажиглан шинжлэх, стратегийг сонгон хэрэглэх болон шаардлагатай үед өөрчлөх боломжийг бүрдүүлдэг. Мета танин мэдэхүй нь шийдвэр гаргалт, суралцах үйл явц, нөхцөл байдлын үнэлгээ болон стрессийн нөхцөлд өөрийгөө удирдах чадавхад чухал нөлөө үзүүлдэг танин мэдэхүйн зохицуулалтын механизм юм.

⁴ Тайлбар: Гипер орон зай (hyper space) нь олон хэмжээс бүхий онолын хийсвэр орон зайн загвар бөгөөд зарим тохиолдолд шинжлэх ухааны уран зөгнөлд орон зайг богино хугацаанд туулан шилжих боломжтой альтернатив орчин гэж дүрслэгддэг.

⁵ Тайлбар: Спектр нь аливаа физик долгион, эсвэл хийсвэр үзэгдлийг түүний бүрэлдэхүүн хэсгүүдээр (давтамж, урт, шинж чанар) задлан ангилсан тархалтын муж болон цогц хүрээг илэрхийлдэг ойлголт юм.

⁶ Тайлбар: Р.С.Бестер (R.S. Bester) нь Өмнөд Африкийн цэргийн сэтгэл судлалын чиглэлээр судалгаа хийдэг эрдэмтэн бөгөөд цэргийн алба хаагчдын байлдааны бэлэн байдал, сэтгэл зүйн тэсвэрлэх чадвар, нэгжийн нэгдэл, манлайлал, энхийг дэмжих ажиллагааны сэтгэл зүйн асуудлуудыг судалснаараа танигдсан судлаач юм.

гүнзгийрч, хүний бие махбод болон оюун санааны биологийн хязгаарлалтыг даван туулах шинэ боломжуудыг бий болгоно гэж үзжээ.

Харин А.Г.Караяни⁷ ирэх арван жилийн хугацаанд дайны шинж чанарт гарах өөрчлөлтөд голлон анхаарч судалсан бөгөөд түүний үзэж байгаагаар ирээдүйн дайнууд нь олон орон зайг хамарсан (multidomain), үл мэдэгдэх байдал, тодорхойгүй байдал, хувьсамтгай чанар, өндөр төвөгшил зэрэг онцлогтой байх болно. Түүнчлэн эдгээр дайнд уламжлалт зэвсэгт тэмцлийн хэлбэрүүд болон “зөөлөн хүч”-ний стратегиуд харилцан уялдан хэрэгжих төлөвтэй байна. Үүнд сэтгэл зүйн ажиллагаа, мэдээллийн нөлөөлөл, террорист үйл ажиллагаа, хувьсгалт жагсаал, хөдөлгөөн зэрэг арга хэрэгслүүдийг өргөн ашиглах бөгөөд зөвхөн цэргийн байгууллага төдийгүй нийгмийн институтууд, хувийн цэргийн компаниуд, энгийн иргэд хүртэл мөргөлдөөний үйл явцад татагдан оролцох болно гэжээ.

А.Г.Караянигийн үзэж байгаагаар ирээдүйн дайн, мөргөлдөөн арван үндсэн орон зайд өрнөх боломжтой. Үүнд хуурай газар, газар доорх орчин, усан гадарга, усан доорх орчин, агаар, сансар, сэтгэл зүйн орон зай, нийгмийн орчин, мэдээллийн орон зай болон кибер орон зай багтана. Эдгээр орон зайн хоорондын зааг ялгаа улам бүр бүдгэрч, харилцан уялдаа нь нэмэгдэх төлөвтэй байна. Ирээдүйн байлдааны талбарт цэргүүд технологийн өндөр хүчин чадалтай дайсантай тулгарахын зэрэгцээ хорлон сүйтгэх ажиллагаа, террорист халдлага, отолт, партизаны ажиллагаа, төрөл бүрийн занга болон гар аргаар хийсэн тэсрэх төхөөрөмж (IED)-ийг өргөн ашигладаг хууль бус зэвсэгт бүлэглэлүүдтэй тэмцэх шаардлагатай болно гэжээ.

Ирээдүй рүү чиглэсэн цэргийн болон иргэний технологийн хамгийн идэвхтэй хөгжиж буй чиглэлүүд, орчин үеийн технологийн хөгжлийн талаар бичигдсэн судалгааны бүтээлүүдэд хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд цэргийн практикийн хөгжилд онцгой ач холбогдолтой байж болох дараах технологийн чиглэлүүдийг тодорхойлж байна.

1. Хиймэл оюун - аналитик ба урьдчилан таамаглах шинжилгээний даалгаврыг түргэсгэх, байлдааны шийдвэр гаргалтыг дэмжих, цэрэг, зэвсэг, техник, хүрээлэн буй орчин, дэд бүтэц зэрэг олон бүрэлдэхүүнтэй цогц байлдааны системийг үр ашигтай удирдах боломжийг бүрдүүлэх, мөн цэрэг бүрийн нөөц чадавхыг (сэтгэл зүйн болон эмнэлгийн өөртөө туслах чадавхыг оролцуулан) нэмэгдүүлэх.
2. Автономит удирдлагатай, олон чиг үүрэг бүхий байлдааны нисгэгчгүй нисэх цогцолборуудыг (Эдгээр нь усан доор нуугдах, усан гадаргуу дээр болон агаарт довтлох зэрэг өөр өөр орчинд шилжин ажиллах чадвартай байна) бүтээн хөгжүүлэх.
3. Агаарын хүчин, пуужингийн систем, нисгэгчгүй нисэх төхөөрөмжүүд болон хуурай газар, усан гадаргуу, усан доорх роботжсон цогц системүүдийн нэгдсэн уялдаа холбоотой ажиллагааг хөгжүүлэх.
4. Байлдааны ажиллагаа газар доорх орчин руу шилжих магадлалтай тул газар доорх барилга, байгууламж, холбоо, дэд бүтцийг хурдан хугацаанд барьж

⁷ Тайлбар: Александр Григорьевич Караяни нь орчин үеийн Оросын цэргийн сэтгэл судлалын хамгийн нэр хүндтэй эрдэмтдийн нэг бөгөөд цэргийн сэтгэл судлалын онол, арга зүй, байлдааны стресс, сэтгэл зүйн хангалт, мэдээлэл-сэтгэл зүйн тэмцэл зэрэг чиглэлээр өргөн хүрээний судалгаа хийсэн судлаач юм.

байгуулах технологийг хөгжүүлэх.

Өнөөгийн зэвсэгт мөргөлдөөнүүдийн явцад бий болж буй ирээдүйн шинжтэй хөгжлийн чиг хандлагууд.

Шинэ үеийн зэвсэгт мөргөлдөөнүүдийн онцлогийг судлах нь (2020 оны Армен–Азербайжаны Уулын Карабахын мөргөлдөөн, 2022 оноос өнөөг хүртэл үргэлжилж буй ОХУ-ын Украйны нутаг дахь цэргийн тусгай ажиллагаа, мөн Иран улсын эсрэг АНУ ба Израилийн явуулж буй сөргөлдөөн зэрэг) орчин үеийн байлдааны арга хэрэгсэл, тактик, стратеги, улс орнуудын цэргийн байгууллын бүтэц (тайван болон дайны цагийн бүтэц зохион байгуулалт), түүнчлэн байлдааны хангалтын агуулга, зохион байгуулалт, байлдааны журамд шинэчлэлийн шинжтэй өөрчлөлтүүд гарч байгааг харуулж байна. Мөн байлдааны ажиллагааг сэтгэл зүйн хувьд дэмжих арга хэлбэрүүд ч эрс шинэчлэгдэж байна. Өнөө үеийн дайн, байлдааны дүр төрх нь Дэлхийн II дайны болон XX зууны төгсгөл, XXI зууны эхэн үеийн зэвсэгт мөргөлдөөнүүдтэй харьцуулахад эрс өөр болж, уламжлалт ойлголтоос үндсэндээ холдож байна.

Дээр дурдсан дайн, байлдаан, зэвсэгт мөргөлдөөнөөс үүссэн сэтгэл зүйн асуудлуудын бодит нөхцөл байдлыг судлах нь өнөө үед явагдаж буй дайн, байлдаан, зэвсэгт мөргөлдөөний нийтлэг шинжүүдийг тодорхойлох боломжийг олгож байна.

Өнөө үеийн дайн, байлдааны үндсэн шинжүүд:

1. Байлдааны ил тод орон зайн ба мэдрэмтгий байдал.

Үнэн хэрэгтээ, өндөр болон бага тойрог замын хиймэл дагуулын бүлэглэлүүд, стратегийн, оперативын, тактикийн, тагнуулын болон цохилтын нисгэгчгүй нисэх төхөөрөмжүүд (ННТ)-ийг өргөнөөр ашиглах болсонтой холбоотойгоор өнөө үеийн дайн, байлдааны талбар үндсэндээ бүрэн хяналттай орчин болж хувирч байна.

Мөн өндөр барилга, байгууламж, суурин объект, ажиллагаа явуулж буй чухал бүсүүдэд тараан байрлуулсан хяналтын дүрс бичлэгийн төхөөрөмж, түүнчлэн цэргийн алба хаагчийн дуулганд байрлуулсан GoPro төрлийн дүрс бичлэгийн төхөөрөмж, мөн цэргийн хөдөлгөөн, үйл ажиллагааг илрүүлэгч бүхий төхөөрөмжийн өргөн хэрэглээ нь өнөө үеийн байлдааны талбарыг айдас төрүүлэх хэмжээний “реалити шоу”-тай төстэй орчин болгон хувиргаж байна. Дээрх нөхцөлд байлдааны ажиллагаа нь хоёр талын байнгын ажиглалтын дор явагдах бөгөөд аливаа хөдөлгөөн, үйлдэл нь ямар ч агшинд илрүүлэгдэж, эсрэг талаас таслан зогсоогдох боломжтой болжээ. Өнөө үед хангалттай сайн нууцлал, өнгөлөн далдлалт хийгээгүй хөдөлж буй цэрэг нь байлдааны талбарт ил харагдах бай болж, эсрэг талын хувьд хамгийн тохиромжтой амьд бай болох нөхцөл бүрдэж байна.

Зарим тохиолдолд байлдааны үүрэг хүлээсэн нэгтгэл, ангиуд эсрэг талынхаа нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн цагийн байдлыг эрсдэлтэйгээр үнэлж, сар гаруй хугацаанд заагдсан газар район руу марш үйлдэж, ямар нэгэн хөдөлгөөн хийж чадахгүй нөхцөл байдал үүсдэг байна. Цэргийн тусгай ажиллагаанд оролцогчдын өгүүлснээр, хоргодох байрнаасаа 150 метрийн зайд орших усны эх үүсвэрээс ус авахаар гарсан цэрэг зарим тохиолдолд дайсны ажиглалт, цохилтын хэрэгслээс зайлсхийж, тохиромжтой мөчийг хүлээсээр гурав хоногийн дараа л байрлалдаа эргэн ирэх нөхцөл үүсдэг байна. Мөн үүнтэй ижил шалтгаанаар шархадсан цэргийн алба хаагчдыг байлдааны талбараас хэдэн өдрийн турш татан гаргаж чадахгүй

байх тохиолдол гардаг бөгөөд учир нь аврах, нүүлгэн шилжүүлэх бүлэг тэдэнд хүрч очихын тулд өөрсдийн амь насыг ноцтой эрсдэлд оруулах шаардлагатай болдог байна. Энэхүү нөхцөл байдал нь орчин үеийн байлдааны талбарын ил тод байдал, тасралтгүй ажиглалт-хяналтын орчин нь зөвхөн байлдааны ажиллагаанд төдийгүй хангалт, эмнэлгийн татан гаргалт зэрэг дэмжлэгийн үйл ажиллагаанд ч ноцтой хүндрэл учруулж байгааг харуулж байна.

2. Зэвсэгт тэмцлийн хэрэгсэл, цэргийн техникийн хөгжил дэх хувьсал өөрчлөлтүүд.

2026 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Израилын Батлан хамгаалах хүчин болон Хезболлагийн хооронд болсон нэгэн тулалдааны явцад Израилын тал нийт 21 нэгж “Меркава” байлдааны танк алджээ гэж тэмдэглэгдсэн байна. Эдгээр танк нь дэлхийн хамгийн шилдэг, хамгийн өндөр хамгаалалттай байлдааны машинд тооцогдож байсан боловч харьцангуй дэвшилтэт бус нисгэгчгүй нисэх төхөөрөмжүүдийн тусламжтайгаар ил тод байдлаар устгагдсан гэж мэдээлжээ.

Цэргийн тусгай ажиллагаа явагдаж буй талбарт танк устгагч робот, өвөр эгнээний тээвэрлэгч, цэргийн тээврийн хэрэгсэл болон бусад ижил төстэй тээврийн хэрэгслүүд цөөн тоогоор идэвхтэй оролцож байгааг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд удаа дараа тэмдэглэж байсан. Хоёр талын олон үүрэгт робот системүүд аль хэдийн бие биетэйгээ тулалдаж байсан тохиолдлууд гарсан.

Цэргийн тусгай ажиллагааны байлдааны орчин болон Ираны агаарын орон зайд бүх төрлийн нисгэгчгүй төхөөрөмжүүд болон радио электрон тэмцлийн системүүдийн хооронд ширүүн өрсөлдөөн өрнөж байна. Үүнд шилэн кабелийн удирдлагатай дронууд өргөн ашиглагдах болсон байна. Мөн хиймэл оюунд суурилсан, гадаад удирдлагаас үл хамааран бие даан ажиллах чадвартай автономит байлдааны нисгэгчгүй цогц системүүдийг хөгжүүлж байгаа бөгөөд ийм төрлийн зэвсгүүд нь өөрөө байлдааны шийдвэр гаргах чадвартай болох чиг хандлага ажиглагдаж байна.

Мөн нисгэгчгүй нисэх төхөөрөмжүүдийн ашиглалтын үр нөлөө тасралтгүй нэмэгдэж байгаа бөгөөд үүнд сум, галт хэрэглэл, тэсэрч дэлбэрэх бодисыг зөөвөрлөх зориулалттай төхөөрөмжүүд, агаарын цель руу мин харвах системүүд, радио электрон тэмцэл (РЭТ)-ээс хамгаалах шийдлүүд, түүнчлэн мөргөлдөх (камикадзе-амиа золиослогч) төрлийн дронуудын эсрэг хамгаалалтын технологиуд зэрэг багтаж байна.

Байлдааны талбарт шилжилт хөдөлгөөн хийхдээ цэргийн тусгай ажиллагааны явцад ихэвчлэн иргэний зориулалттай суудлын автомашин, дөрвөн дугуйт ATV, багги, мотоцикл зэрэг дээр суурилсан байлдагчдын өөрсдөө зохион бүтээсэн “гар хийцийн” тээврийн хэрэгслүүдийг өргөн ашиглах болсон байна. Эдгээр нь хурд, хүч, маневрлах чадвар, үл анзаарагдах байдал болон бүлгийн аюулгүй байдлын үзүүлэлтээр зарим тохиолдолд олон арван жилийн турш хөгжүүлсэн уламжлалт байлдааны техникийг давж гарах тохиолдол ажиглагдаж байна.

3. Цэргийн ажиллагааны тактикийн үндсийг дахин авч үзсэн судалгаа.

Цэргийн тусгай ажиллагааны явцад гарч буй хамгийн тод тактикийн шинэлэг үзэгдлүүдийн нэг нь дайтагч талуудын хооронд “killzone” буюу нарийвчилсан ажиглалт болон бүрэн устгалын бүсүүдийг бий болгосон явдал юм. Эдгээр

бүсүүд нь нисгэгчгүй төхөөрөмжүүд, артиллер, нисэх хүчин, мина-тэсрэх хаалт, урьдчилан онилогдсон их буу ба миномётын галын шугамууд, урт хугацааны бэхлэгдсэн нууц галын цэгүүд, жижиг боловч хүчтэй эсэргүүцлийн зангилаанууд, отолт болон хөдөлгөөнт тагнуул-хорлон сүйтгэх бүлгүүдээр маш өндөр нягтралтай хангагдсан байна.

Ийм орон зайг даван туулах арга замуудыг уламжлалт байлдааны дүрэм, журамд тодорхойлсон байдлаар хэрэгжүүлэх боломж мэдэгдэхүйц буурсан бөгөөд газар дээрх байлдаанд оролцогчид тухайн нөхцөлд тохирсон өөрийн тактикийн шинэ хэлбэрүүдийг хөгжүүлж байна. Үүний хүрээнд дайсанд илрэгдэх магадлалыг эрс бууруулах зорилгоор дайралтын бүлгүүдийн бүрэлдэхүүнийг хамгийн бага түвшинд (зарим тохиолдолд хоёр хүн хүртэл) багасгах, мөн өндөр хурдтай хөдөлгөөнт “хөнгөн” тээврийн хэрэгслүүдийг (иргэний суудлын автомашин, FPV Kamikaze Drone, багги, мотоцикл, мопед, унадаг дугуй гэх мэт тусгайлан тоногдсон хэрэгслүүд) ашиглан хамгийн өндөр хурд, маневрлах чадвараар шилжилт хийх арга давамгайл болж байна. Мөн байлдааны үйл ажиллагааны тодорхой хэсгийг газар доорх орон зайд шилжүүлэх хандлага нэмэгдэж байна.

Үнэн хэрэгтээ, сүүлийн 4 жилийн хугацаанд цэргийн тусгай ажиллагааны хүрээнд ашиглагдсан тохиолдлуудаас харахад орхигдсон дамжуулах хоолой, тусгайлан тоногдсон байлдааны зориулалтай байгууламж, хонгилуудыг ашигласнаар олон жил “давшгүй” гэж тооцогдож байсан дайсны хамгаалалтын шугамыг сэтлэх боломж бүрдсэн тохиолдлууд бүртгэгджээ.

Нээлттэй эх сурвалжийн мэдээллээс үзэхэд байлдаанд оролцож буй бүлгүүдийн бүтэц нь цэргийн тусгай ажиллагааны өмнөх үеийн албан ёсны дүрэм, баримт бичигт тусгагдаагүй шинэ нэгжүүдийг агуулж байна. Үүнд нисгэгчгүй төхөөрөмжийн бүлэг, дайралтын нэгж, бэхжилтийн нэгж зэрэг багтаж байна.

Орчин үеийн байлдааны ажиллагааны чухал онцлог нь олон мянган квадрат километрийг хамарсан өргөн уудам байлдааны орон зайд оролцогч талуудад түр хугацаанд ч болов аюулгүй байдлыг мэдрэх, амрах, унтах, бүрэн нөхөн сэргэлт хийх боломжтой газар бараг үлдэхгүй болсон явдал юм.

Байлдааны ажиллагаанд оролцогчдын дунд байнга сэрэмжтэй байх дадал нь биеийн булчингийн тодорхой хэсгүүдэд тогтмол чангаралт үүсгэж, улмаар хүчтэй булчингийн агшилтуудыг бий болгодог. Ингэснээр булчингийн чангарал, хатуу байдал нь дайн дууссаны дараа ч удаан хугацаанд хадгалагдаж, сэтгэл зүйн болон бие махбодын хэвийн байдалд ороход саад болдог.

Үүний улмаас дайны үеийн сөрөг дурсамжууд хуримтлагдан нэмэгдсээр, хүний сэтгэл зүйд хэт их ачаалал үүсгэдэг. Энэ нь тухайн хүний одоо болж буй зүйлсийг тайван мэдрэх чадварыг бууруулж, ирээдүйн талаар тодорхой, бүрэн дүүрэн бодож төлөвлөх боломжийг нь хязгаарладаг.

Байлдааны ажиллагаанд оролцогчдын зүгээс газар доорх орон зайг өргөнөөр тоноглох явдал түгээмэл болж байна. Эдгээр нь дан бункер бус, харин амралт, хооллох, спортын үйл ажиллагаа явуулах, газар доорх эмнэлэг, сэтгэл зүйн ачаалал бууруулах өрөө, шашны байгууламж, засварын цех ([ПЕН ТВ 2025](#)) зэрэг бүхий жижиг хэмжээний газар доорх “суурин” маягийн бүтэцтэй болсон байна ([Carrie H. Kennedy 2022](#)).

Ийм орчин нь бие махбодын болон сэтгэл зүйн хурцадмал байдлыг түр хугацаанд бууруулах боломж олгодог боловч орчин үеийн байлдааны шинж чанараас шалтгаалан сөрөг дурсамжаас бүрэн салж, сэтгэл зүйн нөхөн сэргэлт хийх боломж хязгаарлагдмал хэвээр байна.

4. *Цэргийн ажиллагаа байлдааны бүсийн хил хязгаараас улам бүр даван өргөжиж байна.* Өнөө үед дайтагч талуудын цохилтод нутаг дэвсгэрийн бүхий л гүнд байрлах онц чухал объектууд өртөх болсон. Үүний зэрэгцээ нисгэгчгүй нисэх төхөөрөмжийг урьдчилан байршуулан гэнэт хөөргөх, мөн отолтын тактик ашиглаж, дайсны объектуудад илрэлгүйгээр ойртон, хамгийн их хохирол учруулах боломжтой шийдвэрлэх мөчид бие биедээ цохилт өгч байна.

Дайтагч талуудын тактикийн үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд нисгэгчгүй нисэх төхөөрөмжүүдийн (ННТ) ашиглалт нь зөвхөн цэргийн объектуудыг устгах үндсэн зорилгоос гадна илүү өргөн хүрээний, шууд бус зорилтуудыг агуулж байгааг харуулж байна. Үүнд:

- Бүс нутагт байрлах агаарын довтолгооноос хамгаалах системийн ажиллагааны загвар, зохион байгуулалтыг илрүүлэх;
- Стратегийн ач холбогдол бүхий объектуудын хамгаалалтын найдвартай байдлыг шалгах, мөн шаардлагатай үед тэдгээрийг эзлэх боломжийг үнэлэх;
- ар иргэдийн дунд айдас, түгшүүр төрүүлэх, улсын хамгаалалтын чадавхад үл итгэх хандлага бий болгох, эрх баригчдын эсрэг сэтгэл ханамжгүй байдлыг өдөөх;
- Цэргийн тусгай ажиллагаатай холбоотойгоор нийгмийн янз бүрийн бүлгүүдийн хооронд хуваагдал, зөрчил үүсгэх.

Энэхүү дүн шинжилгээ нь нисгэгчгүй системийн хэрэглээ, орчин үеийн байлдааны нөхцөлд зөвхөн амьд хүчийг устгах хэрэгсэл бус, харин тагнуул, сэтгэл зүйн нөлөөлөл болон нийгэм-сэтгэл зүйн тогтворгүй байдал үүсгэх олон талт хэрэгсэл болж байгааг илтгэж байна.

5. *Радио электрон тагнуул, хиймэл оюуны элементүүд болон террорист ажиллагааны аргуудыг байлдааны зорилгоор өргөнөөр ашиглах нь иргэн бүрийг ямар ч агишнд зэвсэгт мөргөлдөөний оролцогч эсвэл хохирогч болгох нөхцөлийг бүрдүүлж байна.*

Орчин үеийн амьдралд электрон төхөөрөмжүүдийн асар их хэрэглээ бий болсон нь бидний өдөр тутмын амьдралын секунд бүрийн дуу, дүрсний мэдээллийг бараг бодит цагийн горимоор янз бүрийн компани, байгууллагын серверүүд рүү дамжуулах боломжийг олгож байна. Эцсийн дүнд нь “Palantir Gotham⁸” зэрэг тагнуул-аналитикийн системүүд зөвхөн гар утас, ухаалаг цаг, бугуйвч, ухаалаг телевизор, ухаалаг аудио төхөөрөмжүүдээс төдийгүй хөргөгч, агааржуулагч, цахилгаан данх, индүү зэрэг өдөр тутмын ахуйн төхөөрөмжүүдээс ч мэдээлэл цуглуулах чадвартай болж байна.

Ийнхүү энх тайвны үед тав тухыг хангадаг бүхий л технологиуд нь дайны нөхцөлд тухайн хүний аюулгүй байдлыг алдагдуулах хүчин зүйл болон хувирч

⁸ Тайлбар: Palantir Technologies нь их хэмжээний олон эх үүсвэрт өгөгдлийг нэгтгэн боловсруулж, дүн шинжилгээ хийх, холбоо хамаарлыг илрүүлэх болон шийдвэр гаргалтыг дэмжих хиймэл оюунд суурилсан мэдээллийн аналитикийн платформ хөгжүүлэгч компани юм.

болзошгүй гэж дүгнэжээ.

Ирээдүйн дайны онцлог нь байлдааны ажиллагаанд оролцогчдын сэтгэл зүйд үзүүлэх нөлөөллийн урьдчилсан таамаг. Ирээдүйн дайныг судалж буй мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар ирээдүйн зэвсэгт мөргөлдөөнүүд нь оролцогчдын сэтгэл зүйн ачааллыг хэд дахин нэмэгдүүлж, тэдэнд хоёрдмол, тодорхойгүй байдал, дургүйцэл, стресс зэрэг сэтгэл зүйн төлөвүүдийг илүү хүчтэйгээр үүсгэх хандлагатай байна.

Одоогоос 7 жилийн өмнө А.Г.Караяний дэвшүүлсэн зарим дүгнэлтүүд өнөөдөр ч ач холбогдлоо хадгалж, ойрын ирээдүйн чиг баримжааг тодорхойлж байна. Тухайлбал: “Ирээдүйн дайны дүр зураг нь улс орнуудын цэргийн номлол, цэргийн шинжлэх ухааны судалгааны чиглэл, орчин үеийн байлдааны ажиллагааны хандлага болон ирээдүйн цэргийн технологийг хөгжүүлж буй шинжлэх ухааны асуудлуудад тусгалаа олжээ. Өнөөдөр өрнөж буй ирээдүйн дайны дүр зураг нь шинэлэг, үл анзаарагдах, тодорхойгүй, хувьсамтгай байдлыг агуулж байгаагаараа онцлог болж байна” гэж бичиж байжээ.

Эдгээр шинж чанарууд нь ажигч, сэргэлэн, авхаалжтай, шийдэмгий, эерэг хандлагатай, ганцаар болон бүлгээр ажиллах чадвартай, өргөсөн тангарагтаа үнэнч цэрэг дайчдын хэрэгцээг бий болгож байна. Энэ нь цэргийн сэтгэл судлалын хөгжлийн чиглэлийг тодорхойлох нэгэн төрлийн хөтөч луужин болж байна.

Цэргийн сэтгэл судлал нь ирээдүйн болзошгүй дайн, байлдаан, зэвсэгт мөргөлдөөнийг цогцоор харах өөрийн онол, арга зүйн бүрдүүлэх, шинэ судалгааны чиглэлүүдийг идэвхтэй хөгжүүлэх, мөн байлдааны ажиллагааны стратеги, тактик болон цэргийн алба хаагчдын ёс суртахуун, сэтгэл зүйн бэлэн байдлыг хангахад өөрийн байр суурийг илэрхийлэх түвшинд хөгжих шаардлагатай болж байна.

Иймээс ирээдүйн дайны тактик-сэтгэл зүйн онцлог болон цэргийн сэтгэл судлалын хөгжлийн хэтийн чиг хандлагыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр таамаглахын тулд бид дараах гол хүчин зүйлс (детерминант⁹)-д тулгуурлана:

1. Дэлхийн тэргүүлэх цэргийн гүрнүүдийн батлан хамгаалах номлолын баримтлал. Эдгээр нь олон салбарын эрдэмтэд, байлдааны туршлагатай мэргэжилтнүүд, улс төрчид, футурологичид¹⁰ зэрэг өргөн бүрэлдэхүүнтэй судалгааны багуудын хамтын үр дүн байдаг. Энэ хүрээнд ОХУ-ын Батлан хамгаалах номлол болон АНУ-ын Үндэсний батлан хамгаалах стратегийн агуулга онцгой сонирхол татна.
2. Тодорхой эрдэмтдийн бүтээлүүдэд тусгагдсан ирээдүйн талаарх таамаглалууд.
3. Ирээдүй рүү чиглэсэн хөгжлийн хурдтай цэргийн болон иргэний технологиуд.

⁹ Тайлбар: Детерминант (Determinant) гэдэг үг нь хэрэглэгдэж буй салбараасаа хамааран өөр өөр утгатай боловч үндсэндээ ямар нэг үзэгдэл, үйл явцыг тодорхойлогч, нөхцөлдүүлэгч, шалтгаан бологч хүчин зүйл гэсэн утгыг илэрхийлдэг. Сэтгэл судлал, нийгмийн шинжлэх ухаанд детерминант гэдэг нь хүний зан үйл, сэтгэл зүй, нийгмийн үзэгдэлд нөлөөлж буй гол хүчин зүйлсийг хэлнэ.

¹⁰ Тайлбар: Футуролог (Futurologist) гэдэг нь ирээдүйд гарч болзошгүй өөрчлөлт, чиг хандлага, технологийн хөгжил, нийгэм, эдийн засаг, улс төр, цэрэг-аюулгүй байдлын орчны хувьслыг судалж, таамаглал боловсруулдаг судлаачийг хэлнэ.

4. Одоогийн цэргийн ажиллагааны үйл явцын явцад үүсэж буй футурист шинжтэй шинэ чиг хандлагууд.

Эдгээр хүчин зүйлс нь ирээдүйн дайны тактик-сэтгэл зүйн онцлогийг авч үзэх бидний үндсэн логик хүрээг бүрдүүлнэ. Үүнийг бид дараах цаг хугацааны түвшинд авч үзнэ:

1. Ойрын ирээдүйн түвшин (10 хүртэл жил),
2. Дунд хугацааны ирээдүйн түвшин (25 жил буюу дөрөвний нэг зуун),
3. Алсын ирээдүйн түвшин (50 жил хүртэл)(Gouws 2022).

ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнгээс үзэхэд ирээдүйн дайн нь хиймэл оюун, нисгэгчгүй систем, мэдээллийн болон танин мэдэхүйн ажиллагаанд тулгуурласан олон орон зайг хамарсан шинжтэй болж байна. Үүний зэрэгцээ дайн, байлдааны тактик, техник, технологи, сэтгэл зүйн нөлөөллийн арга хэлбэр эрс өөрчлөгдөж байгаа нь цэргийн сэтгэл судлалын судалгааны шинэ чиглэл, арга зүйг хөгжүүлэх шаардлагыг бий болгож байна.

Иймээс цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн тогтвортой байдал, танин мэдэхүйн чадавх, шинэ нөхцөлд дасан зохицох чадварыг сайжруулах нь цэргийн сэтгэл судлалыг хөгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. Bester, Petrus Cornelius. 2020. *Military psychology and the fourth industrial revolution: Implications for the South African National Defence Force's Directorate psychology*.
2. Carrie H. Kennedy. 2022. “Ethical Dilemmas in Clinical,,” *Military Psychology: Clinical and Operational Applications* 32.
3. 2014. “Внешняя политика/Основополагающие документы.” *Министерство иностранных дел Российской Федерации*. 12 25. Нэвтэрсэн 2026 оны 07 02. https://mid.ru/ru/foreign_policy/official_documents/1584621/.
4. Радио РБК. 2021. *Войны будущего: какими их видят Илон Маск, Митио Каку и другие визионеры*. 03 26.
5. 2025. *Российские бойцы построили подземный город на краснолиманском направлении*. 11 08.
6. Gouws, Jacques. 2022. “Military Psychology: Time to Embrace a Front-Line Diplomatic Role.” *Scientia Militaria* 50 (2). <https://doi.org/10.5787/50-2-1372>.
7. Kulyk, Oleksandr Vasyliovych, and Olena Maidannyk. 2026. “TCCC-ASM in the Russo-Ukrainian War: First Combat Experience as a Factor in the Gap Between Training and Practical Application of Knowledge and Skills Among Mobilized Military Personnel.” Version v1.0. With Oleksandr Vasyliovych Kulyk. Preprint, Zenodo, June 27. <https://doi.org/10.5281/ZENODO.20958548>.
8. Matthews, Michael D. 2020. *Head Strong: How Psychology Is Revolutionizing War, Revised and Expanded Edition*. 1st ed. Oxford University Press New York. <https://doi.org/10.1093/oso/9780190870478.001.0001>.
9. Караяни, А. Г. 2026. “Тактико-психологические черты будущих войн и перспективы военной психологии: Tactical and psychological features of future wars and the prospects of military psychology.” *Russian military psychological journal*, no. 1(11) (March): 9–23. <https://doi.org/10.25629/RMPJ.2026.01.01>.

10. *РЕН ТВ*. 2025. “Российские Бойцы Построили Подземный Город На Краснолиманском Направлении.” November 8. <https://ren.tv/news/v-rossii/1381452-rossiiskie-voennye-postroili-podzemnyi-gorod-na-krasnohimanskom>.